



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 31 өдөр

Дугаар Д/548

Хэрлэн сум


Хүндэтгэл үзүүлэхэд,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Хүний Гавьяат эмч Рэгзэнгийн Эрдэнэбилэг, Гавьяат багш Гэндэнгийн Чимэдцэрэн, Гавьяат тээвэрчин Дагдандоржийн Ганбаатар, Өмнөдэлгэр сумын харьяат Жонан Ханчэн гэгээнтэн нарт хүндэтгэл үзүүлэхэд 1,341,002 (нэг сая гурван зуун дөчин нэгэн мянга хоёр) төгрөгийг хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн шагнал урамшууллын зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023
оны 10 дугаар сарын 31-ны
дугаар захирамжийн хавсралт

ЗАРДАЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэр	Нэг бүрийн үнэ	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Мөнгөн аяга	550,000	ширхэг	1	550,000
2	Хадаг	6,050	ширхэг	7	42,350
3	Ааруул	11,236	500 грамм	7	78,652
4	Талархал	60,000	ширхэг	7	420,000
5	Талархал АЗ	50,000	ширхэг	5	250,000
Нийт					1,341,002